



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Албан тушаал (ажлын байр)-ын жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”, Засгийн газрын 2023 оны 240 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай” тогтоол, Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоол, “Бүтэц орон тооны хязгаарыг батлах тухай” Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/527 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар баталсан Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батласантай холбогдуулан тус газрын бүтэц, орон тооны схемийг нэгдүгээр хавсралтаар, албан тушаал (ажлын байр)-ын жагсаалтыг хоёрдугаар хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан албан тушаал (ажлын байр)-ын жагсаалтын дагуу албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, батлуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Д.Ганболд)-т даалгасугай.

ДАРГА




Д.БАТСҮХ



Нийслэлийн аялал жуулчлалын газрын даргын,
2024 оны... дугаар сарын...-ны өдрийн...
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт


**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН БҮТЦИЙН СХЕМ**



Төрийн захиргааны албан хаагч - 15

Төрийн үйлчилгээний албан хаагч - 3

Нийслэлийн аялал жуулчлалын газрын даргын
 2024 оны... дугаар сарын...-ны өдрийн...
 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
 АЛБАН ТУШААЛ (АЖЛЫН БАЙР)-ЫН ЖАГСААЛТ**

д/д	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Газрын дарга	ТЗ-3	1
Захиргаа, санхүүгийн хэлтэс			
2	Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга	ТЗ-4	1
3	Бодлогын баримт бичгийн тайлан, тогтоол шийдвэр, үйл ажиллагааны хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-7	1
4	Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1
5	Аялал жуулчлалын байгууллагууд, үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1
6	Сургалт, судалгаа, хяналт шинжилгээ үнэлгээ хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1
7	Архив, бичиг хэргийн эрхлэгч	ТҮМ-3	1
Бодлогын хэрэгжилтийн хэлтэс			
8	Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга	ТЗ-4	1
9	Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-7	1
10	Аяллын бүтээгдэхүүний хөгжүүлэлт хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1
11	Эвент хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	2
12	Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1
Мэдээлэл, сурталчилгааны хэлтэс			
13	Мэдээлэл, сурталчилгааны хэлтсийн дарга	ТЗ-4	1
14	Хэвлэл мэдээлэл, олон нийтийн харилцаа хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-7	1
15	Маркетинг сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн	ТЗ-8	1
16	Цахим хөгжүүлэлт, мэдээллийн технологи хариуцсан ажилтан	ТҮ-7	1
17	Жуулчны аюулгүй байдал, мэдээллийн төвүүд хариуцсан менежер	ТҮ-8	1
Нийт тоо			18
Төрийн захиргааны албан хаагч-15			
Төрийн үйлчилгээний албан хаагч-3			